

WEAPONS

Proliferation

**Agreement between the
UNITED STATES OF AMERICA
and MONGOLIA**

Signed at Washington October 23, 2007



NOTE BY THE DEPARTMENT OF STATE

Pursuant to Public Law 89—497, approved July 8, 1966
(80 Stat. 271; 1 U.S.C. 113)—

“ . . .the Treaties and Other International Acts Series issued under the authority of the Secretary of State shall be competent evidence . . . of the treaties, international agreements other than treaties, and proclamations by the President of such treaties and international agreements other than treaties, as the case may be, therein contained, in all the courts of law and equity and of maritime jurisdiction, and in all the tribunals and public offices of the United States, and of the several States, without any further proof or authentication thereof.”

MONGOLIA

Weapons: Proliferation

*Agreement signed at Washington October 23, 2007;
Entered into force February 20, 2008.*

**AGREEMENT
BETWEEN
THE GOVERNMENT OF THE UNITED STATES
OF AMERICA
AND
THE GOVERNMENT OF MONGOLIA
CONCERNING
COOPERATION TO SUPPRESS THE PROLIFERATION OF
WEAPONS OF MASS DESTRUCTION, THEIR DELIVERY
SYSTEMS, AND RELATED MATERIALS BY SEA**

The Government of the United States of America and the Government of Mongolia (hereinafter, "the Parties");

Deeply concerned about the proliferation of weapons of mass destruction (WMD), their delivery systems, and related materials, particularly by sea, as well as the risk that these may fall into the hands of terrorists;

Recalling the 31 January 1992 United Nations Security Council Presidential statement that proliferation of all WMD constitutes a threat to international peace and security, and underlines the need for Member States of the UN to prevent proliferation;

Also recalling United Nations Security Council Resolution 1540 (2004), which calls on all States, in accordance with their national legal authorities and legislation and consistent with international law, to take cooperative action to prevent illicit trafficking in nuclear, chemical or biological weapons, their means of delivery, and related materials;

Mindful of the Convention on the Prohibition of the Development, Production, Stockpiling and Use of Chemical Weapons and on their Destruction, done at Paris 13 January 1993; the Treaty on Nonproliferation of Nuclear Weapons, done at Washington, London and Moscow 1 July 1968; and the Convention on the Prohibition of the Development, Production and Stockpiling of Bacteriological (Biological) and Toxin Weapons and on their Destruction, done at Washington, London and Moscow 10 April 1972;

Further recalling the International Ship and Port Facility Security Code, adopted by the International Maritime Organization on 12 December 2002;

Acknowledging the widespread consensus that proliferation and terrorism seriously threaten international peace and security;

Convinced that trafficking in these items by States and non-state actors of proliferation concern must be stopped;

Guided by the Statement of Interdiction Principles for the Proliferation Security Initiative;

Inspired by the efforts of the International Maritime Organization to improve the effectiveness of the Convention for the Suppression of Unlawful Acts against the Safety of Maritime Navigation, done at Rome 10 March 1988;

Reaffirming the importance of customary international law of the sea as reflected in the 1982 United Nations Convention on the Law of the Sea;

Committed to cooperation to stop the flow by sea of WMD, their delivery systems, and related materials to or from States or non-state actors of proliferation concern;

Have agreed as follows:

Article 1 **Definitions**

In this Agreement, unless the context otherwise requires:

1. "Proliferation by sea" means the transportation by ship of weapons of mass destruction, their delivery systems, and related materials to or from States or non-state actors of proliferation concern.
2. "Weapons of mass destruction" (WMD) means nuclear, chemical, biological and radiological weapons.
3. "Related materials" means materials, equipment and technology, of whatever nature or type, that are related to and destined for use in the development, production, utilization or delivery of WMD.
4. "States or non-state actors of proliferation concern" means those countries or entities that should be subject to interdiction activities because they are or are believed to be engaged in: (1) efforts to develop or acquire WMD or their delivery systems; or (2) trafficking (either selling, receiving, or facilitating) of WMD, their delivery systems, or related materials.
5. "Security Force Officials" means:
 - a. for the United States, uniformed or otherwise clearly identifiable members of the United States Coast Guard and the United States Navy, who may be accompanied by clearly identifiable law enforcement officials of the Department of Homeland Security and/or the Department of Justice, and/or other clearly identifiable officials duly authorized by the Government of the United States of America and notified to the Competent Authority of Mongolia; and
 - b. for Mongolia, uniformed or otherwise clearly identifiable members of the General Intelligence Agency (GIA) of Mongolia, duly authorized by the Government of Mongolia and notified to the Competent Authority of the United States.
6. "Security Force vessels" means warships and other vessels of the Parties, or of third States as may be agreed upon by the Parties, on which Security Force Officials of either or both Parties may be embarked, clearly marked and identifiable as being on government service and authorized to that effect, including any vessel and aircraft embarked on or supporting such vessels.
7. "Suspect vessel" means a vessel used for commercial or private purposes in respect of which there are reasonable grounds to suspect it is engaged in proliferation by sea.

8. "International waters" means all parts of the sea not included in the territorial sea, internal waters and archipelagic waters of a State, consistent with international law.
9. "Competent Authority" means for the United States, the Commandant of the United States Coast Guard (including any officer designated by the Commandant to perform such functions), and for Mongolia, the Chairman, General Intelligence Agency (GIA) of Mongolia (including any officer designated by the Chairman to perform such functions).

Article 2
Object and Purpose of Agreement

1. The object of this Agreement is to promote cooperation between the Parties to enable them to prevent the transportation by ship of WMD, their delivery systems, and related materials.
2. The Parties shall carry out their obligations and responsibilities under this Agreement in a manner consistent with the principles of international law pertaining to sovereign equality and territorial integrity of States, and non-intervention in the domestic affairs of other States.
3. The Parties shall cooperate to the fullest extent possible, subject to the availability of resources and in compliance with their respective laws.

Article 3
Cases of Suspect Vessels

Operations to suppress proliferation by sea pursuant to this Agreement shall be carried out only against suspect vessels claiming nationality in one of the Parties, and against suspect vessels without nationality and suspect vessels assimilated to vessels without nationality.

Article 4
Operations in International Waters

1. Authority to Board Suspect Vessels. Whenever the Security Force Officials of one Party ("the requesting Party") encounter a suspect vessel claiming nationality in the other Party ("the requested Party") located in international waters, the requesting Party may request through the Competent Authority of the requested Party that it:
 - a. confirm the claim of nationality of the requested Party; and
 - b. if such claim is confirmed:

- i. authorize the boarding and search of the suspect vessel, cargo and the persons found on board by Security Force Officials of the requesting Party; and
 - ii. if evidence of proliferation is found, authorize the Security Force Officials of the requesting Party to detain the vessel, cargo and persons on board, pending instructions conveyed through the Competent Authority of the requested Party as to the exercise of jurisdiction in accordance with Article 5 of this Agreement.
2. Contents of Requests. Each request shall contain the basis for the suspicion, the geographic position of the vessel, and, if available the name of the suspect vessel, the registration number, the IMO number, home port, the port of origin and destination, and any other identifying information. If a request is conveyed orally, the requesting Party shall confirm the request in writing by facsimile or e-mail as soon as possible. The requested Party shall acknowledge to the Competent Authority of the requesting Party in writing by e-mail or facsimile its receipt of any written or oral request immediately upon receiving it.
3. Responding to Requests.
 - a. If the nationality is verified, the requested Party may:
 - i. decide to conduct the boarding and search with its own Security Force Officials;
 - ii. authorize the boarding and search by the Security Force Officials of the requesting Party;
 - iii. decide to conduct the boarding and search together with the requesting Party; or
 - iv. deny permission to board and search.
 - b. The requested Party shall answer through its Competent Authority requests made for the verification of nationality within two (2) hours of the receipt of such requests.
 - c. If the nationality is not verified within the two (2) hours, the requested Party may, through its Competent Authority:
 - i. nevertheless authorize the boarding and search by the Security Force Officials of the requesting Party; or
 - ii. refute the claim of the suspect vessel to its nationality.

- d. If there is no response from the Competent Authority of the requested Party within two (2) hours of its receipt of the request, the requesting Party will be deemed to have been authorized to board the suspect vessel for the purpose of inspecting the vessel's documents, questioning the persons on board, and searching the vessel to determine whether it is engaged in proliferation by sea.
4. **Right of Visit.** Notwithstanding the foregoing paragraphs of this Article, the Security Force Officials of one Party ("the first Party") are authorized to board suspect vessels claiming nationality in the other Party that are not flying the flag of the other Party, not displaying any marks of its registration or nationality, and claiming to have no documentation on board the vessel, for the purpose of locating and examining the vessel's documentation. If documentation or other physical evidence of nationality is located, the foregoing paragraphs of this Article apply. If no documentation or other physical evidence of nationality is available, the other Party will not object to the first Party assimilating the vessel to a ship without nationality in accordance with international law.
5. **Use of Force.** The authorization to board, search and detain includes the authority to use force in accordance with Article 9 of this Agreement.
6. **Authority to Detain Suspect Vessels.** If evidence of proliferation by sea is found, the Security Force Officials of the first Party may detain the vessel, cargo, and persons on board pending expeditious disposition instructions from the other Party.
7. **Shipboarding Otherwise in Accordance with International Law.** This Agreement does not limit the right of either Party to conduct boardings of vessels or other activities consistent with international law whether based, inter alia, on the right of visit, the rendering of assistance to persons, vessels, and property in distress or peril, the consent of the vessel master, or an authorization from the flag or coastal State.

Article 5

Jurisdiction over Detained Vessels

1. **Jurisdiction of the Parties.** In all cases covered by Article 4 concerning the vessels of a Party located seaward of any State's territorial sea, that Party shall have the primary right to exercise jurisdiction over a detained vessel, cargo and/or persons on board (including seizure, forfeiture, arrest, and prosecution), provided, however, that the Party with the right to exercise primary jurisdiction may, subject to its Constitution and laws, waive its primary right to exercise jurisdiction and authorize the enforcement of the other Party's law against the vessel, cargo and/or persons on board.

2. Jurisdiction in the contiguous zone of a Party. In cases arising in the contiguous zone claimed by a Party, not involving suspect vessels fleeing from the waters of that Party or suspect vessels claiming the nationality of that Party, in which both Parties have the authority to exercise jurisdiction to prosecute, the Party which conducts the boarding and search shall have the right to exercise jurisdiction.
3. Disposition Instructions. Instructions as to the exercise of jurisdiction pursuant to paragraphs 1 and 2 of this Article shall be given without delay through the Competent Authorities.
4. Form of waiver. Where permitted by its Constitution and laws, waiver of jurisdiction may be granted verbally, but as soon as possible it shall be recorded in a written note from the Competent Authority and be processed through the appropriate diplomatic channel, without prejudice to the immediate exercise of jurisdiction over the suspect vessel by the other Party.

Article 6
Exchange of Information and Notification of
Results of Actions of the Security Forces

1. Exchange of Operational Information. The Competent Authorities of both Parties shall endeavor to exchange operational information on the detection and location of suspect vessels and shall maintain communication with each other as necessary to carry out the purpose of this Agreement.
2. Notification of Results. A Party conducting a boarding and search pursuant to this Agreement shall promptly notify the other Party of the results thereof through their Competent Authorities.
3. Status Reports. The relevant Party, in compliance with its laws, shall timely report to the other Party, through their Competent Authorities, on the status of all investigations, prosecutions and judicial proceedings and other actions and processes, arising out of the application of this Agreement.

Article 7
Conduct of Security Force Officials

1. Compliance with Law and Practices. Each Party shall ensure that its Security Force Officials, when conducting boardings and searches pursuant to this Agreement, act in accordance with its applicable national

laws and policies and with international law and accepted international practices.

2. Boarding and Search Teams.

- a. Security Force Officials from Security Force vessels shall carry out boardings and searches pursuant to this Agreement, and may be assisted by crew members from such vessels, including the vessels of third States as agreed between the Parties.
- b. The boarding and search teams may operate from Security Force vessels of the Parties and from such vessels of other States, according to arrangements between the Party conducting the operation and the State providing the vessel and notified to the other Party.
- c. The boarding and search teams may carry arms.

Article 8
Safeguards

1. Where a Party takes measures against a vessel in accordance with this Agreement, it shall:
 - a. take due account of the need not to endanger the safety of life at sea;
 - b. take due account of the security of the vessel and its cargo;
 - c. not prejudice the commercial or legal interests of the Flag State;
 - d. ensure within available means, that any measure taken with regard to the vessel is environmentally sound under the circumstances;
 - e. ensure that persons on board are afforded the protections, rights and guarantees provided by international law and the boarding State's law and regulations;
 - f. ensure the master of the vessel is, or has been, afforded the opportunity to contact the vessels' owner, manager or Flag State at the earliest opportunity.
2. Reasonable efforts shall be taken to avoid a vessel being unduly detained or delayed.

Article 9
Use of Force

1. Rules. When carrying out the authorized actions under this Article, the use of force shall be avoided except when necessary to ensure the safety of its officials and persons on board, or where the officials are obstructed in the execution of the authorized actions. Any use of force pursuant to this Article shall not exceed the minimum degree of force which is necessary and reasonable in the circumstances.
2. Self-defense. Nothing in this Agreement shall impair the exercise of the inherent right of self-defense by Security Force or other officials of either Party.

Article 10
Exchange and Knowledge of Laws and Policies of Other Party

1. Exchange of Information. To facilitate implementation of this Agreement, each Party shall ensure the other Party is fully informed of its respective applicable laws and policies, particularly those pertaining to the use of force.
2. Knowledge. Each Party shall ensure that its Security Force Officials are knowledgeable concerning the applicable laws and policies in accordance with this Agreement.

Article 11
Points of Contact

1. Identification. Each Party shall inform the other Party, and keep current, the points of contact for communication, decision and instructions under Articles 4 and 5, and notifications under Articles 6 and 16 of this Agreement. Such information shall be updated by and exchanged between the Competent Authorities.
2. Availability. The Parties shall ensure that the points of contact have the capability to receive, process and respond to requests and reports at any time.

Article 12
Disposition of Seized Property

1. Assets seized in consequence of operations undertaken on board vessels subject to the jurisdiction of Mongolia pursuant to this Agreement, shall be disposed of in accordance with the laws of Mongolia.
2. Assets seized in consequence of operations undertaken on board vessels subject to the jurisdiction of the United States pursuant to this Agreement, shall be disposed of in accordance with the laws of the United States.
3. To the extent permitted by its laws and upon such terms as it deems appropriate, the seizing Party may, in any case, transfer forfeited assets or proceeds of their sale to the other Party. Each transfer generally will reflect the contribution of the other Party to facilitating or effecting the forfeiture of such assets or proceeds.

Article 13
Claims

1. Injury or Loss of Life. Any claim for injury to or loss of life of a Security Force Official of a Party while carrying out operations arising from this Agreement shall normally be resolved in accordance with the laws of that Party.
2. Other Claims. Any other claim submitted for damage, harm, injury, death or loss resulting from an operation carried out by a Party under this Agreement shall be resolved in accordance with the domestic law of that Party, and in a manner consistent with international law.
3. Consultation. If any loss, injury or death is suffered as a result of any action taken by the Security Force Officials of one Party in contravention of this Agreement, or any improper or unreasonable action is taken by a Party pursuant thereto, the Parties shall, without prejudice to any other legal rights which may be available, consult at the request of either Party to resolve the matter and decide any questions relating to compensation or payment.

Article 14
Disputes and Consultations

1. Disputes. Disputes arising from the interpretation or implementation of this Agreement shall be settled by mutual agreement of the Parties.
2. Evaluation of Implementation. The Parties agree to consult as necessary to evaluate the implementation of this Agreement and to consider

enhancing its effectiveness. The evaluation shall be carried out at least once a year.

3. Resolving Difficulties. In case a difficulty arises concerning the operation of this Agreement, either Party may request, through the Competent Authorities, consultations with the other Party to resolve the matter.

Article 15

Effect on Rights, Privileges and Legal Positions

Nothing in this Agreement:

- a. is intended to alter the rights and privileges due any individual in any administrative or judicial proceeding;
- b. shall prejudice the position of either Party with regard to international law of the sea, or affect the territorial or maritime boundaries or claims of either Party, as between them or with third States.

Article 16

Cooperation and Assistance

1. The Competent Authority of one Party may request, and the Competent Authority of the other Party may authorize, Security Force Officials to provide technical assistance, such as specialized assistance in the conduct of search of suspect vessels, for the boarding and search of suspect vessels located in the territory or waters of the requesting Party.
2. Nothing in this Agreement precludes a Party from authorizing the other Party to suppress proliferation in its territory, waters or airspace, or to take action involving suspect vessels or aircraft claiming its nationality, or from providing other forms of cooperation to suppress proliferation.

Article 17

Entry into Force and Duration

1. Entry into Force. This Agreement shall enter into force upon an exchange of notes indicating that the necessary internal procedures of each Party have been completed.
2. Termination. This Agreement may be terminated by either Party upon written notification of such termination to the other Party through the

appropriate diplomatic channel. Such termination shall take effect six months from the date of such notification.

3. Continuation of Actions Taken. This Agreement shall continue to apply after termination with respect to any administrative or judicial proceedings regarding actions that occurred during the time the Agreement was in force.


Article 18 **Rights for Third States**

1. The Parties agree that the Government of Mongolia may extend, mutatis mutandis, all rights concerning suspect vessels claiming its nationality under the present Agreement to such third States as it may deem appropriate, on the understanding that such third States shall likewise comply with all conditions set forth in the present Agreement for the exercise of such rights, and subject to agreement by that Party and such third States on the designation of points of contact in accordance with Article 11.
2. Such third States shall enjoy rights and be subject to all conditions governing their exercise as set forth in paragraph 1 of this Article effective on the date of a notification by the third State to that Party that it will comply with the conditions for the exercise of those rights.
3. Such rights shall be revocable by that Party or the third State in writing. Such rights shall be revoked, and the conditions governing their exercise shall cease to apply, effective on the date of notification.
4. Such rights shall be subject to modification by mutual concurrence in writing of that Party and the third State. Upon establishment of such mutual written concurrence by that Party and the third State in question, such rights shall be modified effective on the date agreed between that Party and the third State.

IN WITNESS WHEREOF, the undersigned, being duly authorized by their respective Governments, have signed this Agreement.

DONE AT Washington, this 23rd day of October 2007, in duplicate in the English and Mongolian languages, both texts being equally authentic.

FOR THE GOVERNMENT OF THE UNITED STATES OF AMERICA: **FOR THE GOVERNMENT OF MONGOLIA:**

The image shows two handwritten signatures in black ink. The signature on the left is for the United States of America, and the signature on the right is for Mongolia. Both signatures are written in a cursive, flowing style.

**ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ, ТҮҮНИЙГ ЗӨӨВӨРЛӨХ
СИСТЕМ, ХОЛБОГДОХ МАТЕРИАЛЫГ ДАЛАЙД
ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОХ ТАЛААР ХАМТРАН
АЖИЛЛАХ ТУХАЙ АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР, МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар (цаашид “Талууд” гэх);

Үй олноор хөнөөх зэвсэг (ҮОХЗ), түүнийг зөөвөрлөх систем, холбогдох материалыг ялангуяа далайд дэлгэрүүлэх, түүнчилэн эдгээр зүйлс нь террористын гарт орж болох эрсдэлтэйд сэтгэл гүнээ зовниж;

Бүх төрлийн ҮОХЗ-ийг дэлгэрүүлэх нь олон улсын энх тайван, аюулгүй байдалд заналхийлж байгааг дурдан, ҮОХЗ дэлгэрүүлэхээс урьдчилан сэргийлэх НҮБ-ын гишүүн улсын хэрэгцээг цохон тэмдэглэсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлийн Ерөнхийлөгчийн 1992 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн мэдэгдлийг эргэн санаж;

Цөмийн, химийн буюу биологийн зэвсэг, тэдгээрийг зөөвөрлөх хэрэгсэл, холбогдох материалын хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх талаар хамтарсан арга хэмжээг үндэсний хуулийн эрх бүхий байгууллага, хууль тогтоомж болон олон улсын эрх зүйд нийцүүлэн авахыг бүх улсад уриалсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлийн 1540 (2004) тоот тогтоолыг мөн эргэн санаж;

Химийн зэвсэг боловсруулах, үйлдвэрлэх, хадгалах, хэрэглэхийг хориглох, түүнийг устгах тухай 1993 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр Парис хотноо үйлдсэн конвенц, Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай 1968 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Вашингтон, Лондон, Москва хотноо үйлдсэн гэрээ, Бактериологийн (биологийн) ба хорт зэвсэг боловсруулах, үйлдвэрлэх, хадгалах, хэрэглэхийг хориглох, түүнийг устгах тухай 1972 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Вашингтон, Лондон, Москва хотноо үйлдсэн конвенцийг санаж;

Олон улсын далайн байгууллагаас 2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр батласан Олон улсын хөлөг онгоц, боомтын байгууламжийн аюулгүй байдлын хуулийг цаашид эргэн санаж;

ҮОХЗ дэлгэрүүлэх болон терроризм нь олон улсын энх тайван, аюулгүй байдалд ноцтойгоор заналхийлж буйг нийтээр зөвшөөрч байгааг ухамсарлаж;

ҮОХЗ дэлгэрүүлэхтэй холбоотойгоор улсууд болон улс бус этгээд эдгээр зүйлийг эргэлтэнд оруулахыг зогсоох ёстой гэдэгт итгэл төгс байж;

ҮОХЗ дэлгэрүүлэхээс сэргийлэх санаачлагын Хориглох зарчмын тухай мэдэгдлийг удирдлага болгож;

Далайн навигацийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай 1988 оны 3 дугаар сарын 10-ны өдөр Ром хотноо үйлдсэн конвенцийн үр нөлөөг сайжруулахад оруулж буй Далайн олон улсын байгууллагын хүчин чармайлтыг үнэлж;

Далайн эрх зүйн тухай 1982 оны Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцид тусгасан олон улсын далайн заншлын эрх зүйн чухлыг дахин нотолж;

ҮОХЗ дэлгэрүүлэхтэй холбоотой улсууд буюу улс бус этгээд рүү, эсхүл тэдгээрээс ҮОХЗ, түүнийг зөөвөрлөх систем, холбогдох материалыг далайд тээвэрлэхийг зогсоох талаар хамтран ажиллахаа мэдэгдэж;

Дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл Нэр томъёоны тодорхойлолт

Агуулгын хувьд өөр утга шаардлагагүй бол энэхүү хэлэлцээрт:

1. “ҮОХЗ Далайд дэлгэрүүлэх” гэж ҮОХЗ дэлгэрүүлэхтэй холбоотой улсууд буюу улс бус этгээд рүү, эсхүл тэдгээрээс үй олноор хөнөөх зэвсэг, түүнийг зөөвөрлөх систем, холбогдох материалыг хөлөг онгоцоор тээвэрлэхийг хэлнэ.
2. “Үй олноор хөнөөх зэвсэг” (ҮОХЗ) гэж цөмийн, химийн, биологийн болон радиологийн зэвсгийг хэлнэ.
3. “Холбогдох материал” гэж ҮОХЗ боловсруулах, үйлдвэрлэх, ашиглах эсхүл зөөвөрлөхөд хамаарах бөгөөд уг зорилгоор хэрэглэх ангиллын буюу төрлийн материал, тоног төхөөрөмж болон технологийг хэлнэ.
4. “ҮОХЗ дэлгэрүүлэхтэй холбоотой улсууд, эсхүл улс бус этгээд” гэж (1) ҮОХЗ буюу түүнийг зөөвөрлөх системийг боловсруулах буюу олж авах талаархи хүчин чармайлт гаргах; эсхүл (2) ҮОХЗ, түүнийг зөөвөрлөх систем, эсхүл холбогдох материалын эргэлт (худалдах, хүлээж авах, эсхүл хөнгөлөлт үзүүлэх)-тэй холбогдсон буюу холбогдсон гэж тэднийг үзэж үйл ажиллагааг нь хориглох орнууд буюу этгээдийг хэлнэ.
5. “Аюулгүй байдлын албаны албан тушаалтнууд” гэж:
 - a. Америкийн Нэгдсэн Улсын хувьд, Дотоодын аюулгүй байдлын департамент болон/эсхүл Хууль зүйн департаментын хууль сахиулагч тодорхой танигдах албан тушаалтанг дагалдуулсан Америкийн Нэгдсэн Улсын Эргийн хамгаалалтын алба болон Америкийн Нэгдсэн Улсын Тэнгисийн цэргийн хүчний дүрэмт хувцас бүхий буюу тодорхой танигдах гишүүд болон/эсхүл Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газраас зохих ёсоор эрх олгосон бөгөөд Монгол Улсын эрх бүхий байгууллагад мэдэгдсэн өөрөөр тодорхой танигдах бусад албан тушаалтныг;
 - b. Монгол Улсын хувьд, Монгол Улсын Засгийн газраас зохих ёсоор эрх олгосон бөгөөд Америкийн Нэгдсэн Улсын эрх бүхий байгууллагад мэдэгдсэн Монгол Улсын Тагнуулын Ерөнхий газар (ТЕГ)-ын дүрэмт хувцас бүхий буюу өөрөөр тодорхой танигдах албан тушаалтныг хэлнэ.
6. “Аюулгүй байдлын албаны усан онгоц” гэж аль нэг талын буюу хоёр талын Аюулгүйн байдлын албаны албан тушаалтнууд байрласан засгийн газрын албаны хувьд тодорхой тэмдэг бүхий болон танигдах, энэ үүднээс эрх олгогдсон талуудын, эсхүл талуудын тохиролцсон байж болох гуравдагч улсын байлдааны хөлөг онгоц болон бусад усан онгоц, тэр дундаа аливаа усан онгоц болон нисэх онгоц байрласан, эсхүл тийм усан онгоцны хэсгийг хэлнэ.

7. “Сэжигтэй усан онгоц” гэж арилжааны, эсхүл хувийн зорилгод ашиглаж байгаа бөгөөд ҮОХЗ далайд дэлгэрүүлэхэд холбогдсон гэж сэжиглэх боломжит үндэслэл бүхий усан онгоцыг хэлнэ.

8. “Олон улсын ус” гэж олон улсын эрх зүйн дагуу аливаа улсын нутгийн ус, дотоодын ус болон олтригийн усанд багтаагүй далайн бүх хэсгийг хэлнэ.

9. “Эрх бүхий байгууллага” гэж Америкийн Нэгдсэн Улсын хувьд, Америкийн Нэгдсэн Улсын Эргийн хамгаалалтын албаны командлагч (үүнд тухайн чиг үүргийг гүйцэтгэхээр командлагчаас томилсон аливаа офицер багтана), Монгол Улсын хувьд, Монгол Улсын Тагнуулын Ерөнхий газрын дарга (үүнд тухайн чиг үүргийг гүйцэтгэхээр даргаас томилсон аливаа офицер багтана)-ийг хэлнэ.

2 дугаар зүйл

Хэлэлцээрийн зорилт болон зорилго

1. Энэхүү хэлэлцээрийн зорилт нь ҮОХЗ, түүнийг зөвөөрлөх систем болон холбогдох материалыг хөлөг онгоцоор тээвэрлэхээс сэргийлэх боломжийг талуудад олгохоор талууд хоорондоо хамтран ажиллахыг хөхиүлэн дэмжих явдал болно.

2. Талууд энэхүү хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүрэг, хариуцлагаа улсуудын бүрэн эрхт тэгш байдал болон нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, түүнчилэн бусад улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох талаархи олон улсын эрх зүйн зарчимд нийцсэн байдлаар хэрэгжүүлнэ.

3. Талууд нөөц бололцоо болон өөрсдийн хууль тогтоомжийн дагуу бүрэн хэмжээгээр хамтран ажиллана.

3 дугаар зүйл

Сэжигтэй усан онгоцны тохиолдол

ҮОХЗ далайд дэлгэрүүлэхийг энэхүү хэлэлцээрийн дагуу хориглох үйл ажиллагааг зөвхөн талуудын аль нэгэнд харьяалагдана гэх сэжигтэй усан онгоцны эсрэг, түүнчилэн харьяалалгүй сэжигтэй усан онгоц болон харьяалалгүй усан онгоцтой адилтгах сэжигтэй усан онгоцны эсрэг хэрэгжүүлнэ.

4 дүгээр зүйл

Олон улсын усанд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1. Сэжигтэй усан онгоцны тавцан дээр гарах эрх. Аль нэг талын (хүсэлт гаргагч тал) аюулгүй байдлын албаны албан тушаалтнууд олон улсын усанд байрлаж буй нөгөө талын (“хүсэлт хүлээн авагч тал”) харьяалалтай гэж мэдэгдэж буй сэжигтэй усан онгоцтой учирвал хүсэлт гаргагч тал

хүсэлт хүлээн авагч талын эрх бүхий байгууллагаар дамжуулан дараахь зүйлийн талаар хүсэлт гаргаж болно:

а) хүсэлт хүлээн авагч талын харьяаллыг нотлох; болон

б) хэрэв энэ нь нотлогдсон бол:

i) хүсэлт гаргагч талын аюулгүй байдлын албаны албан тушаалтнуудад усан онгоцны тавцан дээр гарах болон сэжигтэй усан онгоц, тавцан дээр олдсон ачаа, хүнд үзлэг хийх эрх олгох, болон

ii) ҮОХЗ дэлгэрүүлэх талаар нотлох баримт олдсон тохиолдолд хүсэлт хүлээн авагч талын эрх бүхий байгууллагаар дамжуулан энэхүү хэлэлцээрийн 5 дугаар зүйлийн дагуу хэргийн харьяалал хэрэгжүүлэх талаар усан онгоц, тавцан дээрх ачаа болон хүнийг саатуулах эрхийг зааварчилгаа хүлээж буй хүсэлт гаргагч талын аюулгүй байдлын албаны албан тушаалтнуудад олгох.

2. Хүсэлтийн агуулга. Хүсэлт бүрт сэжиглэх болсон үндэслэл, усан онгоцны газар зүйн байршил болон, боломжтой тохиолдолд, сэжигтэй усан онгоцны нэр, бүртгэлийн дугаар, ДОУБ-ын дугаар, түүний харьяалагдах боомт, гарлын болон очих газрын боомт болон аливаа бусад таниулах мэдээллийг дурдана. Хүсэлтийг амаар гаргасан тохиолдолд хүсэлт гаргагч тал хүсэлтээ бичгээр үйлдэж факс, эсхүл и-мэйл-ээр аль болох түргэн нотолно. Хүсэлт хүлээн авагч тал бичгээр, эсхүл амаар гаргасан аливаа хүсэлтийг хүлээн авмагц түүнийг хүлээн авснаа хүсэлт гаргагч талын эрх бүхий байгууллагад бичгээр үйлдэж и-мэйл, эсхүл факсаар мэдэгдэнэ.

3. Хүсэлтэд хариу өгөх.

а. Хэрэв харьяаллыг тогтоосон бол хүсэлт хүлээн авагч тал дараахь арга хэмжээ авч болно:

i) өөрийн аюулгүй байдлын албаны албан тушаалтныг тавцан дээр гаргах, үзлэг хийх шийдвэр гаргах;

ii) хүсэлт гаргагч талын аюулгүй байдлын албаны албан тушаалтанд тавцан дээр гарах, үзлэг хийх эрх олгох;

iii) хүсэлт гаргагч талтай цуг тавцан дээр гарах, үзлэг хийх шийдвэр гаргах; эсхүл

iv) тавцан дээр гарах, үзлэг хийх зөвшөөрөл олгохоос татгалзах.

б. Хүсэлт хүлээн авагч тал харьяаллыг тогтоох тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш хоёр /2/ цагийн дотор өөрийн эрх бүхий байгууллагаар дамжуулан тухайн хүсэлтэд хариу өгнө.

с. Хэрэв харьяаллыг хоёр /2/ цагийн дотор тогтоогоогүй бол хүсэлт хүлээн авагч тал өөрийн эрх бүхий байгууллагаар дамжуулан дараахь арга хэмжээ авч болно:

i. хүсэлт гаргагч талын аюулгүйн байдлын албаны албан тушаалтанд аль ч үед тавцан дээр гарах, үзлэг хийх эрх олгох; эсхүл

ii. сэжигтэй усан онгоц нь өөрийн харьяаллынх гэдгийг няцаах.

d. Хэрэв хүсэлт хүлээн авагч талын эрх бүхий байгууллага хүсэлтийг хүлээн авснаас хойш хоёр /2/ цагийн дотор хариу өгөөгүй тохиолдолд усан онгоцны бичиг баримтыг шалгах, тавцан дээрхи хүмүүсээс мэдүүлэг авах болон тухайн усан онгоцыг ҮОХЗ далайд дэлгэрүүлэхэд оролцсон эсэхийг шалгаж, үзлэг хийх зорилгоор хүсэлт гаргагч тал сэжигтэй усан онгоцны тавцан дээр гарах эрхтэй болсонд тооцно.

4. Нэвтрэх эрх. Энэ зүйлийн өмнөх хэсгүүдийг үл харгалзан аль нэг талын (“эхний тал”) аюулгүй байдлын албаны албан тушаалтнууд нөгөө талын далбааг мандуулаагүй, бүртгэл буюу харьяаллын аливаа тэмдэглэгээг илэрхийлээгүй болон уг усан онгоцны тавцан дээр аливаа бичиг баримт байхгүй байх нөгөө талын харьяалалтай гэгдэж буй тухайн сэжигтэй усан онгоцны байршлыг тодруулах, бичиг баримтыг нь шалгах зорилгоор түүний тавцан дээр гарах эрхтэй. Хэрэв бичиг баримт, эсхүл харьяаллыг нотлох өөр биет нотлох баримт олдвол энэ зүйлийн өмнөх хэсгүүдийг хэрэглэнэ. Хэрэв бичиг баримт, эсхүл харьяаллыг нотлох биет нотлох баримт олдоогүй бол эхний тал олон улсын эрх зүйн дагуу уг усан онгоцыг харьяалалгүй хөлөг онгоцонд тооцохыг нөгөө тал нь эсэргүүцэхгүй.

5. Хүч хэрэглэх. Тавцан дээр гарах, үзлэг хийх болон саатуулах эрхийг энэхүү хэлэлцээрийн 9 дүгээр зүйлийн дагуу хүч хэрэглэх эрх гэж ойлгоно.

6. Сэжигтэй усан онгоцыг саатуулах эрх. ҮОХЗ далайд дэлгэрүүлэх талаар нотлох баримт олдсон тохиолдолд эхний талын аюулгүй байдлын албаны албан тушаалтан нөгөө талаас байршлыг нь шилжүүлэх тухай шуурхай зааварчилгааг ирүүлэх хүртэл усан онгоц, тавцан дээрх ачаа болон хүмүүсийг саатуулж болно.

7. Олон улсын эрх зүйн дагуу хөлөг онгоцны тавцан дээр бусад хэлбэрээр гарах. Энэхүү хэлэлцээр аль нэг тал усан онгоцны ахмадын зөвшөөрснөөр, эсхүл далбааны буюу эргийн улсаас олгосон эрхийг үндэслэн *inter alia* нэвтрэх эрх, аюул буюу ослын үед хүмүүс, усан онгоц, эд хөрөнгөнд туслалцаа үзүүлэх болон усан онгоцны тавцан дээр гарах буюу олон улсын эрх зүйд нийцэх бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрхийг хязгаарлахгүй.

5 дугаар зүйл

Саатуулагдсан хөлөг онгоцны хэргийн харьяалал

1. Талуудын хэргийн харьяалал. Аливаа улсын нутгийн усны хэсэгт байрлаж буй усан онгоцтой холбоотой 4 дүгээр зүйлээр зохицуулсан бүх тохиолдолд тухайн тал саатуулагдсан усан онгоц, тавцан дээрхи ачаа болон/эсхүл хүмүүсийн хувьд (хураах, битүүмжлэх, баривчлах болон мөрдөхийг оролцуулан) хэргийн харьяаллаа хэрэгжүүлэх давуу эрхээр

хангагдах бөгөөд, чингэхдээ хэргийн харьяаллаа хэрэгжүүлэх давуу эрхтэй тухайн тал өөрийн Үндсэн хууль болон хууль тогтоомжийн дагуу хэргийн харьяалал хэрэгжүүлэх давуу эрхээс татгалзаж, усан онгоц, тавцан дээрхи ачаа болон/эсхүл хүмүүсийн талаархи нөгөө талын хууль тогтоомжийг хэрэглэх эрх олгож болно.

2. Аль нэг талын залгаа бүсийн хэргийн харьяалал. Тухайн талын уснаас гадагшаа явж байгаа сэжигтэй усан онгоц, эсхүл тухайн улсын харьяалалтай гэж үзэж буй сэжигтэй усан онгоцтой холбогдолгүй байх хоёр талын мөрдөн байцаалт явуулах эрхтэй залгаа бүсэд гарсан хэргийн хувьд тавцан дээр гарч үзлэг хийж буй тал хэргийн харьяаллаа хэрэгжүүлэх эрхтэй.

3. Шилжүүлэх тухай зааварчилгаа. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсгийн дагуу хэргийн харьяаллаа хэрэгжүүлэх зааварчилгааг эрх бүхий байгууллагаар дамжуулан саадгүй өгнө.

4. Татгалзах хэлбэр. Үндсэн хууль, бусад хууль тогтоомжоор зөвшөөрсөн тохиолдолд хэргийн харьяаллаас татгалзсаныг амаар мэдэгдэж болох боловч үүнийг эрх бүхий байгууллагаас аль болох түргэн бичгийн хэлбэрт оруулж, нөгөө тал сэжигтэй усан онгоцонд өөрийн хэргийн харьяаллаа хэрэгжүүлэх асуудлыг хөндөлгүй холбогдох дипломат шугамаар мэдэгдэнэ.

6 дугаар зүйл

Мэдээлэл солилцох болон аюулгүй байдлын албаны үйл ажиллагааны үр дүнг мэдэгдэх

1. Гүйцэтгэх ажлын тухай мэдээлэл солилцох. Хоёр талын эрх бүхий байгууллага сэжигтэй усан онгоц илрүүлсэн болон эрж олсон тухай гүйцэтгэх ажлын мэдээлэл солилцохыг эрмэлзэж, энэхүү хэлэлцээрийн зорилгыг биелүүлэх шаардлагын дагуу өөр хоорондоо холбоотой байна.

2. Үр дүнг мэдэгдэх. Энэхүү хэлэлцээрийн дагуу тавцан дээр гарч, үзлэг хийж буй тал үр дүнгийн талаар өөрийн эрх бүхий байгууллагаар дамжуулан нөгөө талд шуурхай мэдэгдэнэ.

3. Явцын талаар мэдээлэх. Холбогдох тал энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд үүсэх аливаа мөрдөн байцаалт, мөрдөн мөшгих, шүүх ажиллагаа, бусад үйл ажиллагааны явцын талаар өөрийн хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагаараа дамжуулан нөгөө талд тухай бүрт мэдэгдэнэ.

7 дугаар зүйл

Аюулгүй байдлын албаны албан тушаалтны үйл ажиллагаа

1. Хууль тогтоомж, заншилд нийцүүлэх. Тал бүр өөрсдийн аюулгүй байдлын албаны албан тушаалтан энэхүү хэлэлцээрийн дагуу тавцан дээр

гарах болон үзлэг хийх үедээ холбогдох үндэсний хууль тогтоомж, бодлого болон олон улсын эрх зүй болон хүлээн зөвшөөрөгдсөн заншилд нийцүүлэн үйл ажиллагаа явуулах байдлыг хангана.

2. Тавцан дээр гарах болон үзлэг хийх баг.

a. Аюулгүй байдлын албаны усан онгоцны аюулгүй байдлын албаны албан тушаалтан энэхүү хэлэлцээрийн дагуу усан онгоцны тавцан дээр гарах ба үзлэг хийнэ. Чингэхдээ талуудын тохиролцсоны дагуу гуравдагч улсын усан онгоцыг оролцуулан тухайн усан онгоцны багийн гишүүдээс тусламж авч болно;

b. Усан онгоцны тавцан дээр гарах ба үзлэг хийх багууд үйл ажиллагаа явуулж буй тал болон усан онгоц гаргаж буй бөгөөд нөгөө талд мэдэгдсэн талын хоорондын тохиролцооны дагуу талуудын Аюулгүйн байдлын албаны усан онгоц болон бусад улсын тийм усан онгоцноос үйл ажиллагаа явуулж болно;

c. Тавцан дээр гарах ба үзлэг хийх баг зэвсэг биедээ авч явж болно.

8 дугаар зүйл Хамгаалалт

1. Энэхүү хэлэлцээрийн дагуу усан онгоцны эсрэг арга хэмжээ авч буй тал:

a. Далайд буй амьд биетийн аюулгүй байдалд аюул учруулахгүй байх шаардлагыг зохих анхааралдаа авна;

b. усан онгоцны болон түүний ачааны аюулгүй байдлыг хангахыг зохих анхааралдаа авна;

c. далбааны улсын хууль зүйн сонирхол, эсхүл арилжаанд хохирол учруулахгүй байна;

d. нөхцөл байдлын улмаас усан онгоцтой холбоотой авч буй арга хэмжээ нь байгаль орчинд хор нөлөө үзүүлэхгүй байх явдлыг боломжийн хэрээр хангана;

e. тавцан дээр байгаа этгээдийг олон улсын эрх зүй болон тавцан дээр гарах улсын хууль тогтоомжоор олгосон хамгаалалт, эрх, баталгаагаар хангана;

f. усан онгоцны ахмад усан онгоцны эзэмшигч, менежер, эсхүл далбааны улстай нэн даруй холбоо тогтоох боломж олгоно.

2. Усан онгоцыг зүй бусаар саатуулах, эсхүл хүлээлгэхээс зайлсхийх боломжит арга хэмжээ авна.

9 дүгээр зүйл Хүч хэрэглэх

1. Дүрэм. Энэ зүйлд заасанчлан эрх олгосны дагуу үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ тавцан дээрхи албан тушаалтан болон хүмүүсийн аюулгүй байдлыг хангахад зайлшгүй буюу олгосон эрхийн дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагаанд саад учруулахаас бусад тохиолдолд хүч хэрэглэхээс зайлсхийнэ. Энэ зүйлийн дагуу хүч хэрэглэх нь нөхцөл байдлыг харгалзан зайлшгүй болон боломжит хүч хэрэглэх доод түвшингээс хальж үл болно.
2. Өөрийгөө хамгаалах. Аль ч талын аюулгүй байдлын алба буюу бусад албан тушаалтны өөрийгөө хамгаалах салшгүй эрхийг хэрэгжүүлэхэд энэхүү хэлэлцээрийн аль ч заалт нөлөөлөхгүй.

10 дугаар зүйл Нөгөө талын хууль тогтоомж, бодлогыг солилцох болон мэдэгдэх

1. Мэдээлэл солилцох. Энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийг хөнгөвчлөхийн тулд тал бүр өөрсдийн холбогдох хууль тогтоомж болон бодлого, ялангуяа хүч хэрэглэхтэй холбогдсон хууль тогтоомжийг нөгөө талдаа бүрэн мэдээлэх явдлыг хангана.
2. Мэдлэг. Тал бүр өөрсдийн аюулгүй байдлын албаны албан тушаалтан энэхүү хэлэлцээрийн дагуу хэрэглэгдэх зохих хууль тогтоомж болон бодлоготой холбоотой мэдлэгтэй байх явдлыг хангана.

11 дүгээр зүйл Холбоо тогтоох цэг

1. Таних тэмдэг. Энэхүү хэлэлцээрийн 6 болон 16 дугаар зүйлд заасан мэдэгдэл, мөн 4 болон 5 дугаар зүйлд заасан зааварчилгаа, шийдвэр, холбоо барих цэгийн талаар тал бүр нөгөө талдаа мэдээлнэ. Тухайн мэдээллийг эрх бүхий байгууллага шинэчилж, өөр хоорондоо солилцож байна.
2. Боломж. Холбоо тогтоох цэг нь хүлээн авах, боловсруулах, хүсэлтэд хариулт өгөх болон аль ч үед мэдэгдэх боломжтой байхыг талууд хангана.

12 дугаар зүйл Хураагдсан хөрөнгийг байршуулах

1. Энэхүү хэлэлцээрийн дагуу Монгол Улсын хуулийн харьяаллын усан онгоцны тавцан дээр явуулсан ажиллагааны дүнд хураагдсан эд зүйлсийг Монгол Улсын хуулийн дагуу байршуулна.
2. Энэхүү хэлэлцээрийн дагуу Америкийн Нэгдсэн Улсын хуулийн харьяаллын усан онгоцны тавцан дээр явуулсан ажиллагааны дүнд

хураагдсан эд зүйлсийг Америкийн Нэгдсэн Улсын хуулийн дагуу байршуулна.

3. Хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээ болон тухайн нөхцөлд шаардлагатай гэж үзвэл хураан авч буй тал ямар ч тохиолдолд битүүмжилсэн эд зүйлсийг, эсхүл түүний худалдааны орлого нөгөө талдаа шилжүүлж болно. Тухайн хөрөнгө, орлогыг хураахад хөнгөлөлт үзүүлэх, хэрэгжүүлэхэд нөгөө талын оруулсан хувь нэмрийг шилжүүлэх бүрт ерөнхийдөө тусгана.

13 дугаар зүйл Нэхэмжлэл

1. Гэмтэл учруулах буюу амиа алдах. Аль нэг талын аюулгүй байдлын албаны албан тушаалтан энэхүү хэлэлцээрээс үүдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад амиа алдах буюу гэмтсэнээс үүсэх нэхэмжлэлийг хэвийн байдлаар тухайн талын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

2. Бусад нэхэмжлэл. Энэхүү хэлэлцээрийн дагуу аль нэг талын хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнд үүссэн хохирол, хор уршиг, гэмтэл, үхэл, эсхүл гарзтай холбоотой бусад нэхэмжлэлийг нь олон улсын эрх зүйн дагуу тухайн талын дотоодын хуулиар зохицуулна.

3. Зөвлөгөө. Хэрэв аль нэг талын аюулгүй байдлын албаны албан тушаалтан энэхүү хэлэлцээрийг зөрчиж, эсхүл түүний дагуу тухайн тал аливаа буруу буюу боломжит бус ажиллагаа хэрэгжүүлсний улмаас аливаа гарз, гэмтэл, эсхүл үхэл тохиолдвол боломжтой байж болох аливаа бусад хууль зүйн эрхэд хохирол учруулалгүйгээр уг асуудлыг шийдвэрлэх, нөхөн төлбөр буюу төлбөртэй холбоотой аливаа асуудлыг шийдэх талаар аль нэг талын гаргасан хүсэлтийн дагуу талууд зөвлөлдөнө.

14 дүгээр зүйл Маргаан болон зөвлөлдөөн

1. Маргаан. Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх болон тайлбарлахаас үүссэн маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

2. Хэрэгжилтийг дүгнэх. Энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийг дүгнэх болон үр ашгийг дээшлүүлэх талаар шаардлагатай бол зөвлөлдөхөөр талууд зөвшөөрөв. Жилд наад зах нь нэг удаа хэрэгжилтийг дүгнэж байна.

3. Бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх. Энэхүү хэлэлцээрийн үйл ажиллагаатай холбогдон бэрхшээлтэй асуудал үүссэн тохиолдолд аль нэг тал эрх бүхий байгууллагаараа дамжуулан уг асуудлыг шийдвэрлэхээр нөгөө талтайгаа зөвлөлдөхөөр хүсэлт гаргаж болно.

15 дугаар зүйл
Эрх, эрх ямба болон
хууль зүйн байр суурийн үйлчлэл

Энэхүү хэлэлцээрийн аль ч заалт:

- а. Захиргааны болон шүүн таслах ажиллагаанд аливаа хувь этгээдтэй холбоотой эрх болон эрх ямбыг өөрчлөх чиг санаа агуулаагүй;
- б. олон улсын далайн эрх зүйтэй холбоотой аль нэг талын байр суурьт хохирол учруулахгүй, эсхүл тэдгээрийн хооронд буюу гуравдагч улстай газар нутаг, далайн хилийн зурвасын талаархи аль нэг талын нэхэмжлэлд нөлөөлөхгүй.

16 дугаар зүйл
Хамтын ажиллагаа болон туслалцаа

1. Хүсэлт гаргагч талын нутаг дэвсгэрт, эсхүл усанд байгаа сэжигтэй усан онгоцны тавцан дээр гарах ба үзлэг хийх зорилгоор аюулгүй байдлын хүчний албан тушаалтнуудаас техникийн туслалцаа үзүүлэхийг, тухайлбал, сэжигтэй усан онгоцонд үзлэг хийхэд тусгайлсан туслалцаа үзүүлэхийг аль нэг талын эрх бүхий байгууллага хүсэлт гаргаж болох бөгөөд нөгөө талын эрх бүхий байгууллага нь тийнхүү туслалцаа үзүүлэх эрхийг тэдгээр албан тушаалтанд олгож болно.
2. Аль нэг тал өөрийн нутаг дэвсгэр, ус буюу агаарын орон зайд ҮОХЗ дэлгэрүүлэхийг хориглох, эсхүл харьяалалтай гэж үзэж буй сэжигтэй усан онгоц, эсхүл агаарын хөлөгтэй холбогдуулан арга хэмжээ авах эрхийг нөгөө талдаа олгох, эсхүл ҮОХЗ дэлгэрүүлэхийг хориглох зорилгоор бусад хэлбэрээр хамтран ажиллахыг энэхүү хэлэлцээрийн аль ч заалт хязгаарлахгүй.

17 дугаар зүйл
Хүчин төгөлдөр болох, хүчин төгөлдөр байх хугацаа

1. Хүчин төгөлдөр болох. Энэхүү хэлэлцээр нь тал бүр дотоодынхоо эрх зүйн шаардлагыг биелүүлсэн тухайгаа мэдэгдсэн ноот бичгийг харилцан солилцсон өдрөөс хүчин төгөлдөр болно.
2. Цуцлах. Аль ч тал нөгөө талдаа холбогдох дипломат шугамаар бичгээр мэдэгдэж хэлэлцээрийг цуцалж болно. Цуцлалт нь тийнхүү мэдэгдсэн өдрөөс хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно.
3. Авсан арга хэмжээг үргэлжлүүлэх. Энэхүү хэлэлцээрийг хүчин төгөлдөр байх хугацаанд авсан арга хэмжээний талаархи захиргааны буюу шүүхийн үйл ажиллагааны хувьд үргэлжлүүлэн мөрдөнө.

18 дугаар зүйл
Гуравдагч улсын эрх

1. Энэхүү хэлэлцээрийн дагуу харьяалалтай гэж үзэж буй сэжигтэй усан онгоцтой холбогдох бүх эрхийг Монгол Улсын Засгийн газар шаардлагатай гэж үзсэн тохиолдолд гуравдагч улсад шилжүүлж болно хэмээн талууд тохиролцов. Чингэхдээ уг гуравдагч улс нь тэдгээр эрхийг хэрэгжүүлэхдээ энэхүү хэлэлцээрт тусгагдсан бүх нөхцлийг мөн адил биелүүлнэ гэсэн ойлголтыг үндэслэх бөгөөд 11 дүгээр зүйлийн дагуу харилцах цэгийг тодорхойлох тухай тухайн тал болон гуравдагч улсын хоорондын хэлэлцээрийг мөрдлөг болгоно.
2. Гуравдагч улс тэдгээр эрхийг хэрэгжүүлэх нөхцлийг мөрдөхөө тухайн талд мэдэгдсэн өдрөөс эхлэн гуравдагч улсууд эрх эдэлж, тэдгээр эрхийг хэрэгжүүлэх талаархи энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан бүх нөхцлийг мөрдлөг болгоно.
3. Тухайн тал, эсхүл гуравдагч улс бичгээр мэдэгдэх замаар тэдгээр эрхийг хүчингүй болгож болно. Мэдэгдсэн өдрөөс эхлэн тэдгээр эрх хүчингүй болж, тэдгээрийг хэрэгжүүлэх нөхцлийг мөрдөхийг зогсооно.
4. Тэдгээр эрхийг тухайн тал болон гуравдагч улс бичгээр харилцан тохиролцож өөрчилж болно. Уг асуудлаар тухайн тал болон гуравдагч улс бичгээр харилцан тохиролцоонд хүрмэгц тэдгээр эрхийг тухайн тал болон гуравдагч улс тохиролцсон өдрөөс эхлэн өөрчилсөн гэж үзнэ.

Хэмээснийг нотлон, тус тусын засгийн газраас бүрэн эрх олгогдсон дор гарын үсэг зурагсад энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурав.

Энэхүү хэлэлцээрийг Вашингтон хотноо 2007 оны 10 дугаар сарын 23-ны өдөр англи, монгол хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэр нь адил хүчинтэй байна.

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

